

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 10 дугаар сарын 17-ны өдөр

№ 25/45

Улаанбаатар хот

Гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17 дахь заалт, 76.2 дахь заалт, 80 дугаар зүйл, 89 дүгээр зүйлийн 89.1 дэх заалт, 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэг, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)–ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.4, 9.6.20, 9.6.23 дахь заалт, 14 дүгээр зүйлийн 14.5.4 дэх заалт, 20 дугаар зүйлийн 20.1, 20.4, 20.5 дахь хэсэг, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)–ийн дэргэдэх Аудитын хорооны 2025 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн АХ-25/07 тоот дүгнэлт болон ТУЗ–ийн 2025 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн эчнээ санал хураалтын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн зүгээс өөрийн зээлийн үйл ажиллагааны эрэлтийг хангах, үйл ажиллагааны цаашдын өсөлтийг хадгалах, шаардлагатай үед эх үүсвэрийг тухай бүр авч ашиглах зорилгоор толгой компани “АНД Системс” ХХК–тай “Санхүүжилтийн гэрээ”–г байгуулж, 20,000,000,000 (хорин тэрбум) хүртэл төгрөгийн болон 3,000,000 (гурван сая) хүртэл ам.долларын зээлийн шугамыг 2025 оны 10 дугаар сарын 19–ний өдрийг дуустал ашиглах эрхтэй болохыг дурдсугай.
2. Компанийн зүгээс толгой компани “АНД Системс” ХХК–тай байгуулсан “Санхүүжилтийн гэрээ”–нд нэмэлт өөрчлөлт оруулж, шинэчлэн байгуулах хүсэлт гаргасантай танилцаад:
 - Компанийн зээлийн багц нь 2025 оны III улирлын байдлаар 303.1 тэрбум төгрөг буюу өмнөх оны мөн үеэс 108.5% өссөн, цаашид өсөх боломжтой болохыг харгалзан;
 - Компани нь өөрийн зээлийн бүтээгдэхүүний цар хүрээг нэмэгдүүлж, шинэ харилцагчдадаа санал болгон ажиллахад эх үүсвэрийн хэрэгцээ байгааг харгалзан;
 - Толгой компани “АНД Системс” ХХК–тай байгуулах гэрээний нөхцөл нь санхүүгийн зах зээлийн дундаж үнэтэй дүйцэхүйц бөгөөд зээл олголтын шимтгэл, барьцаа хөрөнгө байхгүй тул Компанид ашигтай болохыг харгалзан;толгой компани “АНД Системс” ХХК–тай байгуулсан “Санхүүжилтийн гэрээ”–нд нэмэлт, өөрчлөлт оруулж, шинэчлэн байгуулахаар шийдвэрлэсүгэй.
3. “Санхүүжилтийн гэрээ”–ний үндсэн нөхцөлийг энэхүү тогтоолын хавсралтаар баталж, тус батлагдсан нөхцөлийн дагуу “Санхүүжилтийн гэрээ”–г шинэчлэн байгуулах, түүнд гарын үсэг зурж баталгаажуулах эрхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)–д олгосугай.
4. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг Компанийн ТУЗ–д эргэн тайлагнахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)–д үүрэг болгосугай.

[Гарын үсэг дараагийн хуудсанд зурав]

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 10 дугаар сарын 17-ны өдөр

№ 25/45

Улаанбаатар хот



ТУЗ-ИЙН ДАРГА

О.БОЛДБААТАР